



Оюутны Эрдэм Шинжилгээний Нийгэмлэг
Тэргүүн. А.Сэвжидмаа

“Симпозиум 2025”

Биологи ба Анагаах ухааны чиглэлээр суралцдаг оюутнуудын эрдэм шинжилгээний бага хурлын удирдамж

Зорилго:

Биологи болон Анагаах ухааны чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж буй судлаач оюутан, залуусын сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэх, бүтээлээ олонд хүргэх, тэдний судалгааны ажлыг дэмжих зорилгоор 2 жил тутамд зохион байгуулагддаг “Symposium-2025” эрдэм шинжилгээний бага хурал 15 дахь удаагаа “Оюутны эрдэм шинжилгээний нийгэмлэг” үүсгэн байгуулагдасны 75 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж байна.

Хамрах хүрээ:

Монгол улсын хэмжээнд Биологи болон Анагаах ухааны чиглэлээр бакалаврт суралцаж буй нийт их дээд сургууль, коллежийн оюутнууд хамрагдах боломжтой.

Хугацаа:

2025 оны 11дүгээр сарын 24-ны өдөр

Хаана:

АШУУИС-ийн Оюутны соёлын төвд

Зохион байгуулагч:

АШУУИС-ийн Оюутны Эрдэм Шинжилгээний

АШУУИС-ийн Оюутны Хөгжил, Удирдлагын Газар

Илтгэлийн хураангуйг хүлээн авах:

Бүтээлийг oeshn@st.mnnums.edu.mn хаягаар 2025 оны 11 сарын 20-ны өдрийг дуустал **PDF** файл хэлбэрээр хүлээн авна. Бүртгэлийн хураамж 40000 төгрөг. Хураамж төлсөн баримтыг бүтээлийн хамт мэйл хаягаар ирүүлнэ үү.

Шалгаруулах шаардлага:

“Symposium-2025” эрдэм шинжилгээний бага хуралд ирүүлсэн бүтээлээс эхний 20 байрны бүтээл нь илтгэлээ хэлэлцүүлж эхний 4 байрыг шалгаруулна.

Шалгаруулах үзүүлэлт:

Оюутны эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийн шагналтан шалгаруулах үзүүлэлтэнд үндсэн болон туслах шалгуур хамрагдана.

Үндсэн шалгуур:

1. Шинжлэх ухаанч байдал
2. Практик ач холбогдол
3. Судалгааны шинэлэг тал
4. Зорилгоо биелүүлсэн байдал
5. Судалгааны арга зүй

Туслах шалгуур:

1. Цаг баримтлал
2. Үзүүлэн материал
3. Илтгэх ур чадвар

Шагналын сан:

- | | |
|----------------|---------------------------|
| I байр 1ш | -Өргөмжлөл, мөнгөн шагнал |
| II байр 1ш | -Өргөмжлөл, мөнгөн шагнал |
| III байр 1ш | -Өргөмжлөл, мөнгөн шагнал |
| Тусгай байр 1ш | -Өргөмжлөл, мөнгөн шагнал |

Холбоо барих:

Утас: 90691020, 89558818

И-мэйл: oeshn@st.mnnums.edu.mn

FB page: Оюутны эрдэм шинжилгээний нийгэмлэг

ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ НИЙГЭМЛЭГ

Symposium 2025

Сэтгүүлд материал хүлээн авах журам

- "Symposium-2025"-д оролцох судлаач оюутнуудын хэлэлцүүлж буй илтгэл нь бусад эрдэм шинжилгээний ажлаас бүтнээр болон хэсэгчлэн хуулбарлаагүй тухайн судлаач оюутан удирдагч багшийн тусламжтайгаар өөрөө бие дааж хийсэн байна.
- ОЭШН нь шаардлага хангаагүй өгүүллийг буцаах, зохих хэмжээнд хүртэл товчлох эрхийг эдэлнэ. Эрдэм шинжилгээний өгүүлэл нь дээрх бүх шаардлагыг хангаж, өгсөн хугацааг хэвлэлд ирүүлсэн хугацаа гэж тооцно.
- Илтгэлийг бүртгүүлсэн өдрөөс эхлэн тухайн илтгэлийг зохиогчийн эрхийн хүрээнд олон нийтэд зарлах, мэдээллэх, ашиглах эрх нь "Оюутны Эрдэм Шинжилгээний нийгэмлэг"-т байна.

Бүтээлд тавигдах шаардлага

1. Өгүүллийн эх нь Arial фонт, үсгийн өндөр 11pt хэмжээтэй, мөр хоорондын зай 1.0, тал бүрээс 2см зайтайгаар A4 хэмжээтэй цаасан дээр 3 нүүрэнд багтааж MSWord 2003-с хойших хувилбараар ".doc" буюу ".docx" өргөтгөлтэй форматыг ашиглан бичнэ.
2. Эрдэм шинжилгээний өгүүлэл нь дараах хэсгүүдээс бүтнэ:
 - Өгүүллийн гарчиг
 - Зохиолчийн овог, нэр, харъяалал
 - Үндэслэл
 - Зорилго Зорилт
 - Хэрэглэгдэхүүн ба арга зүй
 - Үр дүн
 - Дүгнэлт
 - Түлхүүр үг
 - Abstract (Англи хураангуй)
3. Өгүүллийн гарчиг нь 100 хүртэл тэмдэгт ашиглан Bold горимд, үсгийн өндрийг 12pt хэмжээтэйгээр голлуулж бичнэ. (Томоор бичнэ)
4. Судлаачдын нэрсийг Italic горимд үсгийн өндрийг 10pt хэмжээтэйгээр мөрний баруун талд нь бичнэ. Зохиогчийн нэрийн баруун дээд өнцөгт superscript горимд 1,2 гэх мэтээр тэмдэглэн, нэрсийн доор зохиогчийн харъяаллыг бичнэ. 1-р зохиогчийн цахим шуудангийн хаяг бичигдсэн байна. (1-р зохиогч уг судалгааны ажлын үндсэн хэсгийг хийсэн байх, сүүлийн зохиогч уг ажлыг удирдсан байх)
5. Хураангуйг Англи (өгүүллийн нэр болон зохиогчийн овог, нэр, харъяалал) хэлээр тус бүр 500 үгэнд багтааж хавсарган бичнэ.
6. Өгүүлэлд 4-5 түлхүүр үг хэрэглэнэ. Түлхүүр үг ганц тоон дээр, цагаан толгойн үсгийн дарааллаар бичигдсэн нэр үг болон холбоо үг байна.
7. Дэд гарчгуудыг Bold горимд үсгийн өндрийг 11pt хэмжээтэйгээр бичнэ. Цогцолборыг эхлэхдээ "space" буюу "tab" товчийг ашиглана. Цогцолборын өмнө ба ард зай авахгүй. Мөрүүд нь баруун, зүүн талдаа зэрэгцэн тэгш бичигдэнэ. Дэд гарчгуудын араас тодорхойлох цэг авахгүй. Тодотгосон үг, нян, вирус-ийн нэрийг Italic горимд бичнэ.

8. Нийтээр ашиглаж заншаагүй товчилсон үгийг өгүүлэлд хэрэглэхгүй байвал зохино. Товчилсон үгийг эхний удаад бүрэн хэмжээгээр дурдаж, хаалтад товчлолыг дурдсаны дараагаар дахин хэрэглэвэл товчлолыг ашиглана
9. Хуралд ирүүлж буй бүтээл нь өмнө ямар нэгэн эрдэм шинжилгээний хуралд оролцоогүй байх.